

“БАГАНУУР, ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХЖ-ИЙН 2026 ОНЫ II УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИЛ

2026 оны 06 дугаар сарын 19

Багануур дүүрэг

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сарын аяны хүрээнд Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 64 дүгээр ангитай хамтран “Утаажилтын бүсэд гацсан иргэнийг аврах ажиллагаа, гал түймэр унтраах тархалтын дадлага сургалт”-ыг нийт ажилтнуудын дунд амжилттай зохион байгуулан ажилласан. Мөн тус аяны хүрээнд “Ажлын байранд нийгэм, сэтгэл зүйн эрүүл орчныг бүрдүүлцгээе” уриан дор зохион байгуулагдсан арга хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагаа, техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэгдэхүүн, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл мэргэжлийн үйл ажиллагааг сурталчлан оролцсон.




Эрчим хүчний салбарын ажилтнуудын дунд 2 жил тутам зохион байгуулагддаг Спортын 6 төрөлт их наадамд 31 байгууллагын 1300 гаруй тамирчин оролцсон бөгөөд тус компаниас нийт 55 тамирчин өөрийн хурд хүч, авхаалж самбаагаа өрсөлдүүлэн сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй баг алтан медаль, шатарын төрөлд 4 дүгээр байр, гар бөмбөгийн



төрөлд эмэгтэй баг 4 дүгээр байрт тус тус шалгарч багийн нийлбэр дүнгээр шагналт IV байрт шалгаран амжилттай оролцсон.

Олон нийт, хэрэглэгчдэд үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор салбарын цахим хуудсан гэмтэл тасралттай холбоотой 47, сарын бүрийн төлбөрийн мэдээлэлтэй холбоотой 19, цахилгаан зөв хэрэглээ, цахилгааны аюул ослоос урьдчилан сэргийлэх 81 зөвлөмж, мэдээллийг бэлтгэн хүргэсэн.



Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан нийт ажилтнуудын 0-16 насны хүүхдүүдэд гарын бэлэг өгөх, нэг өдрийг хамтдаа өнгөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн тоглоомын талбай болон баярын үйл ажиллагаа явагдах талбайд цахилгааны аюулгүй байдлын үзлэг хийж, илэрсэн ил задгай кабель, цахилгааны холболтын зөрчлийг арилгаж, аюулгүй болгох арга хэмжээг авсан.



Гэр бүлийн харилцааг бэхжүүлэх, эерэг хүмүүжил, хамтын оролцоог дэмжих зорилгоор "Гэр бүлийн канвас зураг"-ийг зурлаа.

Тус арга хэмжээнд гэр бүлийн гишүүд хамтран оролцож, өөрсдийн үзэл бодол, хүсэл мөрөөдөл, гэр бүлийн үнэ цэнэ, эв нэгдлийг илэрхийлсэн канвас зургуудыг бүтээв. Арга хэмжээний үеэр оролцогчид харилцан ойлголцол, хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх боломж бүрдсэн.



"Ажил, мэргэжил, амьдрал" сэдэвт асуулт хариултын агшин хийж, оролцогчдын ажил мэргэжлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэ цэнэ, ажил мэргэжлээ зөв сонгохын ач холбогдлыг ойлгуулах, амьдралын зөв хандлага, төлөвшлийг дэмжих чиглэлээр мэдлэг олгосон.



Дорноговь аймгийн ХАБЭА-н сарын аяны нээлтийн арга хэмжээнд байгууллагын ажилтнуудын хамтаар оролцсон.



ХАБЭА-н сарын аяны хүрээнд нийт ажилтнуудад сургалт зохион байгуулж, мэдлэг бататгах тэмцээн зохион байгуулсан.



Цахим Дорноговь арга хэмжээнд байгууллагын танилцуулга бэлтгэж, цахим үйлчилгээ болон шинээр нэвтэрч байгаа тоноглол, тоолуурын талаар иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.







Сайншанд болон Замын-Үүд хэсгийн ажилтнууд өглөө бүр ажлын байрны дасгалыг хийж хэвшсэн бөгөөд 4-р сард аймгийн Эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хийж хэвшье уриатай тэмцээнд оролцсон.



БЗӨБЦТС ТӨХК-ийн ХАБЭА-н 2-р зөвлөгөөн Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан. Салбарын хамт олон оролцож цаашид хэрэгжүүлэх ажлын талаар саналаа нэгтгэн хүргүүлсэн.



Салбарын удирдлагын зөвлөл Замын-Үүд хэсэгт ажиллаж хэсгийн нийт ажилтнуудтай уулзалт зохион байгуулсан.



Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2026 оны мод тариалалтын өдөрт Сайншанд сумын 6-р багийн нутагт шинээр үүсгэн байгуулагдах цэрцэрлэгт хүрээлэнд Хайлаас мод тарьсан.



Дорноговь аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулсан спортын наадамд салбарын Дартсын баг тамирчид оролцож 2-р байранд орж Мөнгөн медаль авсан.




Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг орон нутгийн Эрчим хүчний байгууллагын ажилтнуудтай хийх уулзалт салбарын ажилтнууд оролцож, мэдээлэл солилцсон.




Замын-Үүд хэсгийн ажилтнуудад Компанийн хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Харилцаа, Хандлага, Ажлын байрны эмх цэгц, Хэрэглэгчтэй хэрхэн зөв харилцах сургалт зохион байгуулсан.



Сайншанд сумын 6-р багийн ажлын албанд Олон Улсын хүүхдийн эрхийн өдрийг тохиолдуулан бэлэг гардуулан өглөө.



Дорноговь аймгийн Биеийн тамир спорт хорооноос зохион байгуулсан Хүн амын бие бялдырн түвшин тогтоох сорилд салбарын төвийн ажилтнууд хамрагдсан.



Салбарын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор салбарын хашаанд цэцэг тарьсан.



“1000 эмэгтэй 1000 амьдрал” нөлөөллийн ажлын хүрээнд хийгдсэн сурталчилгааны мэдээлэл постерыг олон нийтийн хаяг болон өөрийн салбарын цахим хуудсанд түгээв. Нийгмийн хэлэлцүүлгийн сурталчилгаа постерыг өөрийн салбарын цахим хуудас болон байгууллагынхаа группд байрлуулав.


Жил бүрийн 05 сарын 15-ны өдрийг НҮБ-аас “Олон улсын гэр бүлийн өдөр” болгон тэмдэглэдэг.

Энэхүү өдрийг тохиолдуулан Говьсүмбэр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой “Халуун ам бүл” гэр бүлийн хөгжлийг дэмжих төслийн арга хэмжээнд хамт олноороо оролцов.



Дэлхий дахинаа жендэрийн тэгш байдлыг хангах нь тогтвортой хөгжилд хүрэх гол арга зам хэмээн үзэж, жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бүхий л бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээнд нийцүүлэн тусгахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа билээ. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд Хүний эрхийн Үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэгтэй хамтран салбарын нийт ажилтнуудад “Хүний эрх ба жендэр” сургалт зохион байгууллаа. Сургалтын хүрээнд:

- ❖ Жендэр гэж юу вэ?
- ❖ Жендэрийн хэвшмэл ойлголт
- ❖ Жендэрийн ялгаварлан гадуурхалт
- ❖ Жендэрт суурилсан хүчирхийлэл
- ❖ Ажлын байрны бэлгийн дарамт зэрэг сэдвүүдээр ойлголт, мэдээлэл хүргэн хэрвээ ямар нэгэн хүчирхийлэлд та болон таны эргэн тойрны хүмүүс өртсөн тохиолдолд хууль эрх зүйн зохицуулалт, хаана хэнд хандах зэрэг мэдээллүүдийг хүргэлээ.



- ХАБЭА-н сарын аяны хүрээнд нийт ажилтнуудыг багт хуваан эрсдэлийн үнэлгээний шинэ журмаар сургалт зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээ хийсэн. Мөн “Байгууллагын соёл” сэдвээр сургалтыг Дундговь сургалт судалгааны хүрээлэн ТББ-ын багш Э.Мөнхжаргалтай хамтран нийт ажилтнуудад зохион байгуулсан.



- Онцгой байдлын ерөнхий газраас Дундговь аймагт зохион байгуулж буй Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны дуурайлган үзүүлэх дадлага сургуул зохион байгуулагдаж салбрын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдсан.

Тус дадлага сургуульд аймаг, сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, эрүүл мэнд, цагдаа, төрийн болон төрийн бус нийт 11 байгууллагын 121 хүн, 25 техник хэрэгсэлтэйгээр оролцож, гамшгийн үеийн хариу арга хэмжээ, хамтын ажиллагаа, шуурхай удирдлагын зохион байгуулалтыг хэрэгжүүлэн ажиллав.



- 2026.04.30 Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрөөр байгууллагын алба хаагчдад мэдээлэл хүргэн уриалга гаргалаа.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХННАХМ

Х.БОЛОРГЭРЭЛ

